



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 33 (510)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Хуульч сонгон шалгаруулах тухай  
/Шинэчилсэн найруулга/*
- *Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2007 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны есдүгээр сарын 7

№33 (510)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

418.	Хуульч сонгон шалгаруулах тухай /Шинэчилсэн найруулга/	797
419.	Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай	801
420.	Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	802
421.	Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	802
422.	Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	802
423.	Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	802
424.	Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	803
425.	Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	803
426.	Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	803
427.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	803
428.	Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	804

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### ХУУЛЬЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

##### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

##### 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

###### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хуульч сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

###### 2 дугаар зүйл. Хуульч сонгон шалгаруулах тухай хууль тогтоомж

2.1. Хуульч сонгон шалгаруулах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Шүүхийн тухай<sup>2</sup>, Прокурорын байгууллагын тухай<sup>3</sup>, Өмгөөллийн тухай<sup>4</sup>, Нотариатын тухай<sup>5</sup> хууль болон энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "хуульчийн сонгон шалгаруулалт" /цаашид "сонгон шалгаруулалт" гэх/ гэж шүүгчийн албан тушаал эрхлэх сонгон шалгаруулалтад оролцох, өмгөөллийн болон нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах мэргэшлийн шалгалтад оролцох, прокуророор ажиллах этгээд нь мэргэжлийн хангалттай мэдлэг, чадварыг эзэмшсэн эсэхийг шалгаж, гэрчилгээ олгох үйл ажиллагааг;

3.1.2. "хуульч" гэж энэ хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан этгээдийг.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль – Төрийн мэдээлэл<sup>1</sup> эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Шүүхийн тухай хууль – Төрийн мэдээлэл<sup>2</sup> эмхтгэлийн 2002 оны 29 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Прокурорын байгууллагын тухай хууль – Төрийн мэдээлэл<sup>3</sup> эмхтгэлийн 2002 оны 29 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Өмгөөллийн тухай хууль – Төрийн мэдээлэл<sup>4</sup> эмхтгэлийн 2002 оны 21 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Нотариатын тухай хууль – Төрийн мэдээлэл<sup>5</sup> эмхтгэлийн 1997 оны 6 дугаарт нийтлэгдсэн.



## 4 дүгээр зүйл. Хуульч сонгон шалгаруулах үйл ажиллагааны зарчим

4.1. Хуульч сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод байдал, тэгш эрх, шударга бсыг хангах, хууль дээдлэх, хараат бус байх, нууцыг чандлан хадгалах, шударга өрсөлдөөний зарчмыг баримтална.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Хуульч сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах

#### 5 дугаар зүйл. Орон тооны бус зөвлөл

5.1. Хуульч сонгон шалгаруулах ажлыг орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.

5.2. Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүнд нь Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Монголын өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч, Монголын нотариатчдын танхимын Ерөнхийлөгч, Улсын ерөнхий прокурорын газрын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгжийн дарга, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх хууль зүйн сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын захирал орно.

5.3. Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, харилцах данстай байна.

5.4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд шийдвэрээ олонхийн саналаар гаргана.

5.5. Зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

#### 6 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх

6.1. Зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. сонгон шалгаруулалтын шалгалтын /цаашид "шалгалт" гэх/ даалгавар боловсруулах ажлыг зохион байгуулах;

6.1.2. сонгон шалгаруулалт явуулах газар, хугацааг товлон зарлах;

6.1.3. шалгалтын хорооны бүрэлдэхүүнийг томилох, чөлөөлөх;

6.1.4. энэ хуулийн 12, 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан этгээдийг сонгон шалгаруулалтад оролцуулахаар бүртгэх;

6.1.5. сонгон шалгаруулалтын явцад хяналт тавих;

6.1.6. сонгон шалгаруулалтын дүнг мэдээлэх;

6.1.7. сонгон шалгаруулалтад тэнцсэн этгээдэд гэрчилгээ олгох, хууль тогтоомжид заасан журмын дагуу гэрчилгээг хүчингүй болгох;

6.1.8. сонгон шалгаруулалттай холбогдсон журам, заавар батлах;

6.1.9. Зөвлөлийн дотоод үйл ажиллагаатай холбогдсон журам тогтоох;

6.1.10. тухайн жилийн сонгон шалгаруулалтад шаардагдах зардлын төсвийг батлах, гүйцэтгэлийн тайланг гаргах;

6.1.11. шалгалтын хорооны саналыг үндэслэн шалгалтын даалгаврын бүтэц, даалгаврын гүйцэтгэлийг дүгнэх, үнэлгээ өгөх, шалгалтын нэгдсэн дүн гаргах журам тогтоох;

6.1.12. сонгон шалгаруулалтын зохион байгуулалттай холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэсэн шалгалтын хорооны шийдвэрийг үл зөвшөөрч гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;

6.1.13. шалгалтын даалгаврын сан бүрдүүлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулах;

6.1.14. энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан хууль зүйн үргэлжилсэн сургалтын багц цагийг тогтоох, түүнийг тооцох журмыг батлах, гэрчилгээ авсан этгээд сургалтын багц цагийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих.

6.2. Зөвлөл энэ хуулийн 6.1.4, 6.1.13, 6.1.14-т заасан бүрэн эрхээ бусад байгууллага, иргэнээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.

#### 7 дугаар зүйл. Зөвлөлийн ажлын алба, түүний чиг үүрэг

7.1. Зөвлөлийн ажлын албаны үүргийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж гүйцэтгэж, дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1. хуульч бэлтгэх, сонгон шалгаруулах асуудлаар Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.2. хуульчдын нэгдсэн бүртгэл хөтөлөх;

7.1.3. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

#### 8 дугаар зүйл. Шалгалтын хороо

8.1. Шалгалтын хороо /цаашид "хороо" гэх/ нь шүүх, прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон өмгөөлөл, нотариатын байгууллагад ажиллаж байгаа хуульч, эрх зүйн салбарын багш, эрдэмтдээс бүрдэнэ.

8.2. Хорооны бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулалт явуулах тухай бүрт Зөвлөлөөс

томилох бөгөөд шалгагчдын нэрсийн жагсаалт нь сонгон шалгаруулалт явуулах өдөр, цаг хүртэл байгууллагын нууцад хамаарна.

8.3. Хороо нь Зөвлөлөөс баталсан журмын дагуу дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.3.1. шалгалтыг зохион байгуулах;

8.3.2. сорилгын шалгалтын дүнг шалгуулагчдын нууц дугаараар мэдээлэх;

8.3.3. сонгон шалгаруулалтад оролцогчийн даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх;

8.3.4. шалгалтын дүнг үнэн зөв нэгтгэн Зөвлөлд хүргүүлэх;

8.3.5. шалгалтын зохион байгуулалт болон даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөхтэй холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэх;

8.3.6. тухайн шалгалтын даалгаврын боловсруулалт, даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөх аргачлалыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах.

8.4. Хорооноос энэ хуулийн 8.3-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь аливаа байгууллага, албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

8.5. Хороо нь сонгон шалгаруулалттай холбогдон үүссэн маргаантай асуудлаар Зөвлөлд санал оруулах эрхтэй.

8.6. Хорооны гишүүдэд урамшуулал олгох бөгөөд хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Хуульч сонгон шалгаруулах журам

#### 9 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтын шалгалт

9.1. Сонгон шалгаруулалтын шалгалт нь эрх зүйн ерөнхий мэдлэгийг сорьсон сорилгын шалгалт болон эрх зүйн салбарын хүрээнд тодорхой өгөгдлийг хууль хэрэглэж шийдвэрлэх бодлогын шалгалтын хэлбэрээр явагдана.

9.2. Шалгалтын зорилго нь шалгалтад оролцогчийн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, хууль зүйн зөвлөгөө өгөх мэргэжлийн хангалттай мэдлэг, чадвар эзэмшсэн эсэхийг тогтооход чиглэнэ.

9.3. Шалгалтын үргэлжлэх нийт хугацаа 3 хоног байна.

9.4. Сонгон шалгаруулалтад оролцогч сорилгын шалгалтын нийт онооны 60, түүнээс дээш

хувийг авсан бол бодлогын шалгалтад орох эрхтэй болно.

9.5. Сорилго болон бодлогын шалгалтад авсан нийлбэр дүн нь сонгон шалгаруулалтын шалгалтын нийт онооны 70, түүнээс дээш хувьд хүрсэн бол сонгон шалгаруулалтад тэнцсэнд тооцно.

9.6. Шалгалтын нэгдсэн дүнг шалгалт дууссанаас хойш ажлын 14 өдөрт багтаан Зөвлөлөөс нууцалсан дугаараар гаргаж, сонгон шалгаруулалтад оролцогчдод мэдээлнэ.

#### 10 дугаар зүйл. Сонгон шалгаруулалт явуулах газар, хугацаа

10.1. Зөвлөл сонгон шалгаруулалтыг жилд нэг удаа товлон зарлаж, нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулна.

10.2. Сонгон шалгаруулалтын товыг шалгалт эхлэхээс 75-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

10.3. Сонгон шалгаруулалтын товд шалгалтын хуваарь, бүртгэх, шалгалт авах газар, хугацаа, шалгалтын дарааллыг заана.

#### 11 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтын шалгалтын даалгавар

11.1. Зөвлөл шалгалтын даалгавар, түүний хариултыг хуульч, эрх зүйн салбарын багш, эрдэмтдээр гэрээний үндсэн дээр урьдчилан бэлтгүүлэн авч болох бөгөөд энэ нь сонгон шалгаруулалт явуулах өдөр, цаг хүртэл байгууллагын нууцад хамаарна.

11.2. Сонгон шалгаруулалтад оролцогчийн даалгаврын гүйцэтгэлийн хуудсыг нууцалсан тоогоор дугаарлах бөгөөд дугаартай холбогдох нэрсийн жагсаалт нь байгууллагын нууцад хамаарна.

11.3. Шалгалтын даалгаврын гүйцэтгэлийг хуульч, эрх зүйн салбарын багш, эрдэмтдээс бүрдсэн гурваас доошгүй шалгагчийн бүрэлдэхүүнтэйгээр дүгнэж, дүнг тэдгээрээс өгсөн үнэлгээний дунджаар гаргана.

#### 12 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтад оролцох

12.1. Дор дурдсан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй.

12.1.1. эрх зүйн чиглэлээр суралцаж бакалаврын болон түүнээс дээш зэргийн боловсрол эзэмшиж, мэргэжлээрээ хоёроос доошгүй жил ажилласан.

12.1.2. ял шийтгэлгүй.

## 13 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтад оролцох тухай өргөдөл гаргах

13.1. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан этгээд сонгон шалгаруулалтад оролцох тухай өргөдлөө Зөвлөлд гаргана.

13.2. Өргөдөл хүлээн авах хугацааг сонгон шалгаруулалтын тов зарласан өдрөөс эхлэн тооцох бөгөөд энэ хугацаа нь шалгалт авах өдрөөс 30 хоногийн өмнө дуусгавар болно.

13.3. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөлд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

13.3.1. Монгол Улсын иргэний үнэмлэх, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний хувьд гадаад улсын паспорт болон түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

13.3.2. эрх зүйн бакалаврын болон түүнээс дээш боловсролын зэргийн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

13.3.3. ял шийтгэлгүй болохыг нотолсон эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

13.3.4. Зөвлөлөөс баталсан маягтын дагуу бөглөсөн өргөдөл гаргагчийн биеийн байцаалтын тодорхойлолт.

13.4. Зөвлөл болон сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх этгээд нь сонгон шалгаруулалтад оролцох тухай өргөдөл, биеийн байцаалтын үнэн зөв байдлыг шалгах зорилгоор шаардлагатай баримт бичиг, мэдээ сэлтийг гаргуулахаар байгууллага, албан тушаалтанд хүсэлт гаргах, өргөдөлд хавсаргасан баримт бичгийн хуулбарыг эх хувьтай нь тулгаж үзэх эрхтэй.

## 14 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах

14.1. Дор дурдсан үндэслэл байвал Зөвлөл сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзана:

14.1.1. өргөдөл гаргагч энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

14.1.2. энэ хуулийн 13.3-т заасан баримт бичгийг бүрдүүлээгүй буюу хуурамчаар бүрдүүлсэн;

14.1.3. сонгон шалгаруулалтын товд заасан хугацаанд бүртгүүлээгүй.

## 15 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтад дахин оролцох

15.1. Сонгон шалгаруулалтад тэнцээгүй болон энэ хуулийн 18.1.1-д зааснаас бусад

үндэслэлээр гэрчилгээгээ хүчингүй болгуулсан этгээд сонгон шалгаруулалтад дахин оролцох эрхтэй.

## 16 дугаар зүйл. Гэрчилгээ олгох

16.1. Зөвлөл сонгон шалгаруулалтад тэнцсэн этгээдэд гэрчилгээ олгох бөгөөд түүний загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.2. Гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд дахин олгох журмыг Зөвлөл тогтооно.

16.3. Гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн холбогдох хуульд заасны дагуу шүүгчийн албан тушаал эрхлэх сонгон шалгаруулалтад оролцох, нотариатын болон өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах мэргэшлийн шалгалтад оролцох, прокуророор ажиллах эрхтэй.

16.4. Гэрчилгээ авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн Өмгөөллийн тухай хуульд заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах мэргэшлийн шалгалтад оролцох эрхтэй.

16.5. Зөвлөлөөс хуульчийн овог, эцэг/эх/-ийн нэр, нэр, сонгон шалгаруулалтад орсон он, шалгалтад авсан оноо, төгссөн сургууль, ажлын туршлагын талаархи мэдээллийг нийтэд мэдээлж болно.

## 17 дугаар зүйл. Хууль зүйн үргэлжилсэн сургалт

17.1. Хуульч нь хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, 3 жил тутам сургалтын тодорхой багц цаг хангаж байх үүрэг хүлээнэ.

17.2. Хууль зүйн үргэлжилсэн сургалт /цаашид "сургалт" гэх/ нь хуульчийн мэдлэг, мэргэшлийн түвшин, үр чадварыг эрх зүйн онолын орчин үеийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэл, шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжлийн шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, эрх зүйт төрийн зарчим, мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга, хараат бус, бүтээмжтэй ажиллах арга ажиллагааг хэвшүүлэхэд чиглэнэ.

17.3. Шүүх, прокурорын байгууллагад ажиллагсдын сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүгнэ.

17.4. Хуульчийн сургалтад хамрагдах журмыг Зөвлөл тогтооно.

## 18 дугаар зүйл. Гэрчилгээг хүчингүй болгох

18.1. Зөвлөл гэрчилгээг дор дурдсан үндэслэлээр хүчингүй болгоно:

18.1.1. Энэ хуулийн 13.3-т заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь шалгалт өгч тэнцсэнээс хойш илэрсэн;

18.1.2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй;

18.1.3. Шүүхийн тухай хуулийн 59.1-д заасан үндэслэлээр шүүгч огцорсон, Прокурорын байгууллагын тухай хуулийн 44.1.4-т заасны дагуу прокурор ажлаас халагдсан, нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Нотариатын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 6, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Өмгөөллийн тухай хуулийн 19.1.3, 19.1.5-д заасан үндэслэлээр тус тус хүчингүй болгосон.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

## 19 дүгээр зүйл. Сонгон шалгаруулалтын санхүүжилт

19.1. Сонгон шалгаруулалтад оролцох нэг оролцогчид ногдох зардлын хэмжээг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

19.2. Сонгон шалгаруулалтад оролцогч энэ хуулийн 19.1-д заасан зардлыг өөрөө хариуцна.

## 20 дугаар зүйл. Сонгон шалгаруулалтын нууцыг хамгаалах

20.1. Энэ хуулийн 8.2, 11.1, 11.2-т заасан этгээд сонгон шалгаруулалтын нууцыг задруулахыг хориглоно.

20.2. Энэ хуулийн 20.1-д заасан сонгон шалгаруулалтын нууцыг задруулсан этгээдийг

сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд оролцуулахгүй.

## 21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зорчигчид хүлээлгэх хариуцлага

21.1. Энэ хуулийн 8.3.4, 8.4, 20.1-ийг зөрчсөн этгээдийг шүүгч 60000 төгрөгөөр торгоно.

## 22 дугаар зүйл. Сонгон шалгаруулалттай холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэх

22.1. Сонгон шалгаруулалтад оролцогч нь сонгон шалгаруулалтын зохион байгуулалттай холбогдсон гомдлоо шалгалт өгсөн өдрөөс хойш ажлын 3 өдөрт, даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөхтэй холбогдсон гомдлыг сорилгын шалгалтын дүн гарсан, эсхүл шалгалтын нэгдсэн дүнг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор Хороонд тус тус бичгээр гаргаж болно.

22.2. Гомдол гаргагч сонгон шалгаруулалтын зохион байгуулалттай холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэсэн Хорооны шийдвэрийг үл зөвшөөрвөл шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор гомдлоо Зөвлөлд гаргаж болно.

22.3. Хороо, Зөвлөл гомдлыг хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор тус тус хянан шийдвэрлэнэ.

22.4. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалттай холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэсэн Зөвлөлийн болон даалгаврын гүйцэтгэлийг дүгнэж, үнэлгээ өгөхтэй холбогдсон гомдлыг хянан шийдвэрлэсэн Хорооны шийдвэр тус тус эцсийн байна.

## 23 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

23.1 Энэ хуулийг 2007 оны 8 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### ХУУЛЬЧДААС СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2003 оны 5 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Хуульчдаас сонгон шалгаруулах тухай Монгол Улсын хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульч сонгон

шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 17.9 дэх хэсгийг дор дурдснаар өөрчлөн найруулсугай.

хуулийн 17.3-т заасан мэргэшлийн шалгалтаас чөлөөлөгдөнө.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульч сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

“17.9. Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцэн гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн шүүгчийн албан тушаал эрхлэх, прокуророор ажиллахад энэ

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн тухай хуулийн 28.1.3-ын “Хуульчдаас” гэснийг “Хуульч” гэж өөрчилсүгэй.

шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульч сонгон

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Прокурорын байгууллагын тухай хуулийн 39.1 дэх хэсгийн “Хуульчдаас” гэснийг “Хуульч” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульч сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Прокурорын байгууллагын тухай хуулийн 45.1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Өмгөөллийн тухай хуулийн 5.1, 16.2, 16.4 дэх хэсгийн “Хуульчдаас” гэснийг “Хуульч” гэж тус тус өөрчилсүгэй.

шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульч сонгон

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нотариатын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Хуульчдаас" гэснийг "Хуульч" гэж өөрчилсүгэй. шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульч сонгон

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Тагнуулын байгууллагын тухай хуулийн 17.2 дахь хэсгийг хүчингүй болсон тооцсугай. шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульч сонгон

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын цагдаагийн байгууллагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан иргэнийг цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар томилно." гэснийг хассугай. **2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульч сонгон шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132.4 дэх хэсгийн "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан." гэснийг хассугай. шалгаруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хуульч сонгон

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН 2007 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 12 дугаар зүйл нэмсүгэй.

**12 дугаар зүйл.** Улсын төсөв болон "Монгол Улсыг хөгжүүлэх сан"-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэлийн явц, төсөвт өртөг, ашиглалтад оруулах хугацаа, тэргүүлэх ач холбогдлыг харгалзан Төсвийн ерөнхийлөн захирагчдын саналыг үндэслэн батлагдсан хөрөнгийн дүнд

багтаан тэдгээрийн санхүүжилтэд зохицуулалт хийх эрхийг Засгийн газарт олгосугай."

**2 дугаар зүйл.** Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн 5, 6, 8, 9 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

**1/5 дугаар зүйл:**

**5 дугаар зүйл.** Улсын төсөвт 2007 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нар тэдгээрийн харьяа байгууллагууд, бусад байгууллагуудын төвлөрүүлэх орлогын дүнг дор дурдсанаар тогтоосугай.

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /мянган төгрөгөөр/
1.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,500.0 1,500.0
	2.	Монгол Улсын Ерөнхий сайд
Төрийн өмчийн хороо		29,988,500.0
Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн төв харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого		2,139,000.0 3,168,420.6
3.	Монгол Улсын Шадар сайд	2,105,520.0
	Оюуны өмчийн газар	11,000.0
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	2,094,520.0
4.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	904,918.9
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	904,918.9
5.	Гадаад хэргийн сайд	11,360,503.7
	Дипломат төлөөлөгчийн газрууд	6,831,112.5
	Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар	915,201.6
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	3,614,189.6
6.	Сангийн сайд	1,336,283,160.5
	Үндэсний татварын ерөнхий газар	939,575,004.0
	Улсын гаалийн ерөнхий газар	374,991,800.0
	Сангийн яам	21,006,374.6
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	709,981.9
7.	Хууль зүй, дотоод хэргийн сайд	6,260,402.1
	Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв	883,064.8
	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба	531,609.2
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	4,845,728.1
8.	Байгаль орчны сайд	4,183,670.6
	Байгаль орчныг хамгаалах алба	3,111,802.8
	Усны хэмнэлтийн төв	390,000.0
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	681,867.8
9.	Батлан хамгаалахын сайд	1,138,422.7
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,138,422.7
10.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	6,762,714.0
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	8,762,714.0

11.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	220,357,535.1
	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар	212,336,696.3
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	98,869.0
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	7,921,969.8
12.	Үйлдвэр, худалдааны сайд	23,338,009.7
	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар	21,233,931.6
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	2,104,078.1
13.	Хүнс, хөдөө аж ахуйн сайд	177,567.7
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	177,567.7
14.	Эрүүл мэндийн сайд	4,499,014.7
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,499,014.7
15.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	116.9
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	116.9
16.	Үндэсний статистикийн газрын дарга	11,340.0
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	11,340.0
17.	Түлш, эрчим хүчний сайд	1,946,678.7
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,946,678.7
18.	Зам тээвэр, аялал жуулчлалын сайд	63,071,755.7
	Иргэний нисэхийн ерөнхий газар	30,032,400.0
	Улаанбаатар төмөр зам	806,800.0
	Төмөр замын хэрэг эрхлэх газар	428,000.0
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	31,804,555.7
19.	Улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд	1,780,649.7
	Улсын мэргэжлийн хяналтын газар	1,000,000.0
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	780,649.7
20.	Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд	2,081,880.0
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,081,880.0
21.	Барилга, хот байгуулалтын сайд	5,620,249.6
	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар	1,000,000.0
	харьяалагдах төсөвт бусад байгууллагын өөрийн орлого	4,620,249.6
22.	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	160,000.0
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	160,000.0
23.	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз	1,398,444.3
	харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,398,444.3

**2/6 дугаар зүйл:**

нарт дор дурдсан төсөв зарцуулах эрхийг

**"6 дугаар зүйл.** Улсын төсвөөс 2007 оны олгосугай.

төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /мянган төгрөгөөр/
1.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	1,611,040.4
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	0.0
2.	Монгол Улсын Их Хурлын дарга	5,284,947.9
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	400,000.0
3.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга	196,751.2
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	15,000.0
4.	Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч	483,036.1
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	23,200.0
5.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	5,438,550.1
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	680,000.0
6.	Улсын ерөнхий прокурор	3,833,294.2
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	567,500.0
7.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	216,538.9
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	0.0
8.	Монгол Улсын Ерөнхий сайд	20,418,183.7
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	9,518,500.0
9.	Монгол Улсын Шадар сайд	6,518,969.3
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	1,020,000.0
10.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	10,249,216.6
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	4,799,500.0

11.	Гадаад хэргийн сайд	16,896,992.2
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	2,840,000.0
12.	Сангийн сайд	448,918,727.9
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	23,110,000.0
13.	Хууль зүй, дотоод хэргийн сайд	117,871,123.8
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	11,848,000.0
14.	Байгаль орчны сайд	11,023,515.6
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	2,073,000.0
15.	Батлан хамгаалахын сайд	38,839,493.5
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	2,561,900.0
16.	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	270,574,938.9
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	35,777,100.0
17.	Барилга, хот байгуулалтын сайд	20,042,925.8
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	13,076,200.0
18.	Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд	111,422,388.3
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	40,684,400.0
19.	Түлш, эрчим хүчний сайд	32,483,335.7
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	19,196,900.0
20.	Улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд	8,036,928.4
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	1,060,000.0
21.	Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд	24,628,475.7
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	4,905,000.0
22.	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	438,476,967.8
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	2,930,600.0
23.	Үйлдвэр, худалдааны сайд	9,804,414.5
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	3,099,400.0
24.	Хүнс, хөдөө аж ахуйн сайд	29,681,978.4
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	10,959,100.0
25.	Эрүүл мэндийн сайд	145,360,361.8
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	20,701,100.0
26.	Төрийн албаны зөвлөлийн дарга	253,401.3
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	0.0
27.	Сонгуулийн ерөнхий хорооны дарга	163,477.6
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	40,000.0
28.	Хүний эрхийн үндэсний комиссын дарга	126,538.6
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	0.0
29.	Үндэсний ерөнхий аудитор	347,899.5
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	50,000.0
30.	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	486,972.1
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	20,000.0
31.	Үндэсний статистикийн газрын дарга	1,559,836.4
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	90,000.0
32.	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга	622,610.4
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	150,000.0
33.	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз	7,541,055.2
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	0.0
34.	Авлигатай тэмцэх газрын дарга	1,901,680.7
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	400,000.0
35.	Аймаг, нийслэлийн Засаг дарга	9,418,000.0
	үүнээс хөрөнгө оруулалтын зориулалтаар	9,418,000.0

**3/8 дугаар зүйл:**  
**"8 дугаар зүйл** Улсын төсвөөс 2007 оны

төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг дор дурдсанаар баталсугай.

д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ (мянган төгрөгөөр)
1.	Архангай	1,443,974.7
2.	Баян-Өлгий	1,426,251.1
3.	Баянхонгор	1,135,295.0
4.	Булган	198,711.2
5.	Говь-Алтай	2,085,518.2

6.	Дорнод	692,206.0
7.	Дундговь	1,482,665.7
8.	Завхан	2,255,814.4
9.	Өвөрхангай	920,758.8
10.	Сүхбаатар	511,059.7
11.	Төв	713,167.7
12.	Увс	2,154,966.5
13.	Ховд	2,007,405.9
14.	Хөвсгөл	1,997,106.8
15.	Хэнтий	1,451,702.6
16.	Говьсүмбэр	689,728.4
	<b>Нийт дүн</b>	<b>21,216,632.7</b>

**4/9 дүгээр зүйл:**

улсын төсөвт татан төвлөрүүлэх орлогын хэмжээг

**"9 дүгээр зүйл** Аймаг, нийслэлийн төсвөөс

дор дурдсанаар баталсугай.

д/д	Аймаг, нийслэл	Татан төвлөрүүлэх орлогын хэмжээ /мянган төгрөгөөр/
1.	Дорноговь	668,508.4
2.	Өмнөговь	1,644,332.9
3.	Сэлэнгэ	3,893,112.1
4.	Дархан-Уул	326,768.3
5.	Улаанбаатар	1,556,359.7
6.	Орхон	18,883,688.7
	<b>Нийт дүн</b>	<b>26,972,770.1</b>

**3 дугаар зүйл.** Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн "1,293,327,332.9" гэснийг "1,612,920,509.2" гэж, 4 дүгээр зүйлийн 1,420,319,159.8" гэснийг "1,722,128,094.4" гэж, 7 дугаар зүйлийн "139,864,400.0" гэснийг "222,014,400.0" гэж, 10 дугаар зүйлийн "164,177,000.0" гэснийг "186,350,800.0" гэж, мөн зүйлийн "10,000,000.0" гэснийг "12,672,831.6" гэж, 12 дугаар зүйлийн дугаарыг "13" гэж тус тус өөрчилсүгэй.

хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг баталсан нэгдүгээр хавсралтад болон "Монгол Улсыг хөгжүүлэх сан"-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг баталсан хоёрдугаар хавсралтад оруулах нэмэлтийг энэ хуулийн нэг, хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг 2007 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**4 дүгээр зүйл.** Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

**Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралт**

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ  
НЭМЭЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН  
ЖАГСААЛТ**

/Төсвийн ерөнхийлөн захирагчаар сая төг/

Төсөвт өртөг	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадвал, байршил		Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг	2007 онд санхүүжих
1	2		3	4	5
I. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	1.1	Хөрөнгө оруулалт:		8,398.5	8,398.5
	1.1.1	Мэдээлэл, харилцаа, холбоо, технологийн газар		6,048.5	6,048.5
	1.1.1.1	ИТХ-ын дэргэдэх телевизийн нэвтрүүлэг дамжуулах станц суурилуулах /Баян-Өлгий/	2007	10.0	10.0

	I.1.1.2	Телевизийн 4 сувгийн нэвтрүүлэг дамжуулах станц суурилуулах /Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Уньт, Хонгор баг, Сэлэнгэ сумын Атар, Сэлэнгэбүрэн баг, Сайхан сумын Сайхан-Овоо баг, Орхон сумын Халиун баг/	2007	38.5	38.5
	I.1.1.3	Хөдөлгөөнт холбооны сүлжээгээр хөдөөгийн иргэдийг хангах зорилгоор үндсэн сүлжээний хөрөнгө оруулалт /60 сум/	2007	6,000.0	6,000.0
	I.1.2	<b>Төрийн тусгай хамгаалалтын газар</b>		<b>2,350.0</b>	<b>2,350.0</b>
	I.1.2.1	Их Тэнгэр цогцолборын гадна фасадын шинэчлэл	2007	350.0	350.0
	I.1.2.2	Их Тэнгэр цогцолборын инженерийн шугам сүлжээний ажил	2007	2,000.0	2,000.0
		<b>Нийт дүн</b>		<b>8,398.5</b>	<b>8,398.5</b>
II. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	II.1	<b>Хөрөнгө оруулалт:</b>		<b>2,266.6</b>	<b>1,946.6</b>
	II.1.1	ЗДТГ-ын к/онторын барилгын зураг, төсөв /Дорнод/	2007	95.0	95.0
	II.1.2	ЗДТГ-ын конторын барилга /Сүхбаатар, Баруун-Урт/	2007	83.6	83.6
	II.1.3	ЗДТГ-ын конторын барилга /Булган, Сайхан/	2007	80.0	80.0
	II.1.4	Найрамдал төвийн дэргэд Хүүхдийн соёлын ордон-спортын цогцолбор	2007-2008	500.0	180.0
	II.1.5	2008 оны төсөл арга хэмжээний зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах	2007	75.0	75.0
	II.1.6	ЗДТГ-ын конторын барилгын дээврийн шинэчлэл /Сэлэнгэ, Ерөө/	2007	25.0	25.0
	II.1.7	ЗДТГ-ын конторын барилга /Архангай, Өлзийт/	2007	30.0	30.0
	II.1.8	ЗДТГ-ын конторын барилгын зураг, төсөв /Баянхонгор, Галуут/	2007	11.0	11.0
	II.1.9	Багийн ЗД-ын конторын барилга /Баян-Өлгий, Бугат сум, 3-р баг/	2007	13.0	13.0
	II.1.10	Булган хотын гэрэлтүүлэг /Булган/	2007	10.0	10.0
	II.1.11	Багийн ЗД-ын конторын барилга /Дорнод, Хэрлэн сум, 4-р баг/	2007	20.0	20.0
	II.1.12	ЗДТГ-ын конторын барилга /Дундговь, Сайнцагаан/	2007	86.0	86.0
	II.1.13	ЗДТГ-ын конторын барилга /Завхан, Цэцэн-Уул/	2007	40.0	40.0
	II.1.14	ЗДТГ-ын конторын барилгын өргөтгөл /Завхан, Цагаанхайрхан/	2007	15.0	15.0
	II.1.15	ЗДТГ-ын конторын барилга /Өвөрхангай, Уянга/	2007	250.0	250.0
	II.1.16	ЗДТГ-ын конторын барилга /Сүхбаатар, Уулбаян/	2007	25.0	25.0
	II.1.17	Багийн ЗД-ын конторын барилга /Сэлэнгэ, Шаамар/	2007	50.0	50.0
	II.1.18	ЗДТГ-ын конторын барилга /Төв, Баянжаргалан/	2007	120.0	120.0
	II.1.19	ЗДТГ-ын конторын барилга /Увс, Өндөрхангай/	2007	50.0	50.0
	II.1.20	ЗДТГ-ын конторын барилга /Увс, Малчин/	2007	50.0	50.0
II.1.21	ЗДТГ-ын конторын барилга /Увс, Тэс/	2007	50.0	50.0	

II.1.22	ЗДТГ-ын харьяанд хүнсний ногоо боловсруулах үйлдвэр байгуулах /Ховд, Буянт/	2007	20.0	20.0
II.1.23	ЗДТГ-ын харьяаны зочид буудал, ахуйн үйлчилгээний барилгын өргөтгөл /Ховд, Мягад/	2007	30.0	30.0
II.1.24	Сумын төвийн гэрэлтүүлэг /Дорноговь, Эрдэнэ/	2007	20.0	20.0
II.1.25	Хотын гэрэлтүүлэг /Дорнод, Чойбалсан/	2007	25.0	25.0
II.1.26	Гэр хорооллын гэрэлтүүлэг /Өвөрхангай, Арвайхээр 18 ш/	2007	28.0	28.0
II.1.27	Хорооны ЗД-ын контор, цагдаагийн хэсгийн байр /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 19-р хороо/	2007	70.0	70.0
II.1.28	Гэр хорооллын автобусны зогсоол /Ховд, Жаргалант/	2007	3.0	3.0
II.1.29	Гэр хорооллын гэрэлтүүлэг /Ховд, Жаргалант/	2007	5.0	5.0
II.1.30	Аймгийн төвийн гэрэлтүүлэг /Булган/	2007	30.0	30.0
II.1.31	ЗДТГ-ын конторын барилга /Дундговь, Сайнцагаан/	2007	70.0	70.0
II.1.32	Ахмадын амралт, чөлөөт цагийн төвийн барилга, түүний тохижилт /Дорнод, Хэрлэн сумын 2, 3-р баг/	2007	100.0	100.0
II.1.33	Хот тохижилт /Баянхонгор, Баянхонгор/	2007	30.0	30.0
II.1.34	Багийн ЗД-ын конторын барилга /Төв, Бүрэн/	2007	70.0	70.0
II.1.35	Сумын төвийн гэрэлтүүлэг /Төв, Лүн/	2007	20.0	20.0
II.1.36	Хотын гэрэлтүүлэг /Төв, Зуунмод/	2007	60.0	60.0
II.1.37	Захиргаа, эмнэлгийн барилга /Хөвсгөл, Бүрэнтогтох, Сангийн далай баг /	2007	7.0	7.0
II.2	<b>Их засвар:</b>		<b>1,231.1</b>	<b>1,113.5</b>
II.2.1	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Сэлэнгэ/	2007	100.9	100.9
II.2.2	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Дархан-Уул/	2007	30.3	30.3
II.2.3	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Дархан-Уул, Дархан/	2007	98.0	98.0
II.2.4	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Ховд/	2007	222.6	130.0
II.2.5	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Хөвсгөл/	2007	55.0	55.0
II.2.6	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Увс, Тэс/	2007	51.0	26.0
II.2.7	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Завхан, Их-Уул/	2007	32.7	32.7
II.2.8	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Завхан, Асгат/	2007	25.0	25.0
II.2.9	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Төв, Цээл/	2007	25.0	25.0
II.2.10	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Төв, Лүн/	2007	35.0	35.0
II.2.11	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Төв, Баянцагаан/	2007	50.0	50.0
II.2.12	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Баянхонгор, Өлзийт, Шаргалжуут тосгон/	2007	20.0	20.0



II.2.13	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Баянхонгор/	2007	50.0	50.0
II.2.14	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Дундговь, Эрдэнэдалай/	2007	50.0	50.0
II.2.15	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Баянхонгор, Эрдэнэцогт/	2007	12.0	12.0
II.2.16	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Баянхонгор, Бууцгаан/	2007	10.0	10.0
II.2.17	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Баянхонгор, Баянбулаг/	2007	10.0	10.0
II.2.18	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Баянхонгор, Гурванбулаг/	2007	10.0	10.0
II.2.19	Багийн ЗД-ын конторын барилгын засвар /Баянхонгор, Жаргалант/	2007	6.5	6.5
II.2.20	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Баянхонгор, Баянлиг/	2007	4.0	4.0
II.2.21	ЗДТГ-ын конторын барилгын халаалтын засвар /Баянхонгор, Баацагаан/	2007	5.0	5.0
II.2.22	ЗДТГ-ын конторын барилгын халаалтын засвар /Баянхонгор, Хүрээмарал/	2007	10.0	10.0
II.2.23	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Баян-Өлгий, Дэлүүн/	2007	15.0	15.0
II.2.24	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Баян-өлгий, Толбо/	2007	10.0	10.0
II.2.25	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Дорноговь, Хөвсгөл/	2007	16.0	16.0
II.2.26	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Завхан, Отгон/	2007	14.0	14.0
II.2.27	Багуудын ЗД-ын конторын барилгын засвар, тохижилт /Ховд, Жаргалант/	2007	6.0	6.0
II.2.28	ИТХ, багийн ИНХ-ын танхим, багуудын ЗД-ын конторын барилгын засвар, тохижилт /Ховд, Жаргалант/	2007	10.0	10.0
II.2.29	Багийн ЗД-ын конторын барилгын засвар, улаан булан, эмнэлгийн засвар, /Ховд, Булган сумын Баянсудалт баг/	2007	9.0	9.0
II.2.30	Сумын ЗДТГ, багийн ЗД-ын конторын барилгын засвар, конторын тавилга /Хөвсгөл, Жаргалант/	2007	20.0	20.0
II.2.31	ЗДТГ-ын конторын барилгыг нэгдсэн халаалтад холбох /Хөвсгөл, Тосонцэнгэл/	2007	25.0	25.0
II.2.32	ЗДТГ-ын конторын барилгын засвар /Хөвсгөл, Рашаант/	2007	10.0	10.0
II.2.33	Багийн төв тохижуулах /Увс аймгийн Наранбулагийн Улаан үзүүр, Хужирт, Завханы Цагаангүнгэ, Өлгийн Хулст нуур баг/	2007	12.0	12.0
II.2.34	Орон сууцны гадна фасадны засвар /Дорнод, Хэрлэн сумын 2, 3-р баг/	2007	14.0	14.0
II.2.35	Их засвар	2007	112.1	112.1
II.2.36	Сумын ЗДТГ-ын конторын барилгын засвар /Төв, Алтанбулаг/	2007	40.0	40.0
II.2.37	Тосон багийн төвийг засварлах /Хөвсгөл, Цагаан-Уул /	2007	5.0	5.0
II.3	<b>Тусног тохөөрөмж:</b>		<b>429.4</b>	<b>429.4</b>
II.3.1	ЗДТГ-ын тээврийн хэрэгсэл /Баян-Өлгий, Дэлүүн/	2007	12.0	12.0

II.3.2	ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Төв/	2007	29.4	29.4
II.3.3	ЗДТГ-ын тээврийн хэрэгсэл /Хэнтий, Жаргалтхаан/	2007	12.0	12.0
II.3.4	7 сумын төсвийн байгууллагуудын тоног төхөөрөмж, компьютер, техник хэрэгсэл /Төв/	2007	20.0	20.0
II.3.5	Багийн ЗД-ын тээврийн хэрэгсэл /Баянхонгор, Баянбулаг/	2007	3.0	3.0
II.3.6	Багийн ЗД-ын тээврийн хэрэгсэл /Баянхонгор, Гурванбулаг/	2007	4.5	4.5
II.3.7	ЗДТГ-ын нийтийн тээврийн зориулалттай автобус /Баян-Өлгий, Бугат/	2007	8.0	8.0
II.3.8	Сумдын ЗДТГ-ын компьютер, техник хэрэгсэл, /Булган аймаг/	2007	19.1	19.1
II.3.9	11 сумын төсвийн байгууллагуудын тоног төхөөрөмж, тохижилт /Завхан/	2007	50.0	50.0
II.3.10	9 сумын төсвийн байгууллагын тоног төхөөрөмж, засвар, тохижилт /Төв/	2007	75.0	75.0
II.3.11	Компьютер мэдээллийн төвийн компьютер, техник хэрэгсэл /Өмнөговь, Баян-Овоо/	2007	5.0	5.0
II.3.12	Хот тохижуулахын парк шинэчлэлт /Ховд/	2007	25.0	25.0
II.3.13	ЗДТГ-ын тээврийн хэрэгсэл, компьютер, соёлын төвд хөгжмийн зэмсэг /Хөвсгөл, Жаргалант/	2007	10.0	10.0
II.3.14	Багийн Засаг дарга, сумын хүний эмч, хэсгийн төлөөлөгчийн тээврийн хэрэгсэл /Булган, 36 баг, 9 сум/	2007	97.2	97.2
II.3.15	Сумдын ЗДТГ-ын компьютер, тоног төхөөрөмж /Булган/	2007	23.2	23.2
II.3.16	ЗДТГ-ын компьютер, тоног төхөөрөмж /Ховд, Мөст/	2007	3.0	3.0
II.3.17	ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Төв, Лүн/	2007	13.0	13.0
II.3.18	Хог хаягдал, ахуйн үйлчилгээний зориулалттай трактор /Ховд, Манхан/	2007	5.0	5.0
II.3.19	Хилийн цэргийн заставын компьютер, техник хэрэгсэл /Ховд/	2007	10.0	10.0
II.3.20	ЗДТГ-ын тээврийн хэрэгсэл /Баянхонгор, Баацагаан/	2007	5.0	5.0
	<b>Нийт дүн</b>		<b>3,927.1</b>	<b>3,489.5</b>
<b>III. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛ-ТЫН САЙД</b>	<b>III.1 Хоронго оруулалт:</b>		<b>5,516.2</b>	<b>4,916.2</b>
III.1.1	2008 оны төсөл арга хэмжээний зураг төсөл, ТЭЗУ боловсруулах	2007	1,000.0	1,000.0
III.1.2	Цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14-р хороолол/	2007	1,911.0	1,911.0
III.1.3	Багануур дүүргийн 58 айлын инженерийн шугам сүлжээ, дулаан дамжуулах төвийн барилгын ажлын дутуу санхүүжилт /Улаанбаатар/	2007	89.0	89.0
III.1.4	Үерээс хамгаалах далан барих /Дархан/	2007-2008	550.0	100.0
III.1.5	Цэвэр бохир усны шугамын засвар /Өмнөговь, Баяндалай/	2007-2008	200.0	50.0
III.1.6	Усан хангамжийн системийн шинэчлэл /Дархан, Хонгор/	2007	380.0	380.0

III.1.7	4 айлын орон сууц /Өмнөговь, Манлай/	2007	35.0	35.0
III.1.8	3 айлын орон сууц /Өмнөговь, Баян-Овоо/	2007	30.0	30.0
III.1.9	3 айлын орон сууц /Өмнөговь, Цогтцэций/	2007	25.0	25.0
III.1.10	4 айлын орон сууц /Өмнөговь, Ханбогд/	2007	35.0	35.0
III.1.11	4 айлын орон сууц /Өмнөговь, Ханхонгор/	2007	35.0	35.0
III.1.12	Төрийн албан хаагчдын орон сууц барихад дэмжлэг үзүүлэх /Увс, Улаангом/	2007	125.0	125.0
III.1.13	Орон сууцны барилгын дээврийн засвар /Орхон, Жаргалант/	2007	20.7	20.7
III.1.14	Орон сууцанд лифт тавих /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо, 6 ш/	2007	60.0	60.0
III.1.15	Орон сууц худалдан авах, зээлээр орон сууц барихад дэмжлэг үзүүлэх /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо/	2007	200.0	200.0
III.1.16	Замын гэрэлтүүлэг /Орхон, Жаргалант/	2007	15.5	15.5
III.1.17	Замын гэрэлтүүлэг /Орхон, Баян-Өндөр, Шанд баг, 6.5 км/	2007	42.0	42.0
III.1.18	Замын гэрэлтүүлэг /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2007	30.0	30.0
III.1.19	Орон сууцны барилгын засвар /Дархан-Уул, Дархан/	2007	250.0	250.0
III.1.20	Нийтийн халуун усны барилга /Баян-Өлгий, Өлгий, Хотгор баг/	2007	10.0	10.0
III.1.21	Ахуйн үйлчилгээ, халуун усны барилга /Дорнод, Хэрлэн, 1-р баг/	2007	29.0	29.0
III.1.22	Гүний худагтай халуун усны барилга /Ховд, 2 ш /	2007	70.0	70.0
III.1.23	Буянт голын ус хуваарилах байгууламжийн дуусгал /Ховд/	2007	40.0	40.0
III.1.24	Халуун усны барилга /Орхон, Баян-Өндөр, Дэнж баг/	2007	50.0	50.0
III.1.25	Хороодын усан сан, гүнийн худаг /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 6-9-р хороо/	2007	15.0	15.0
III.1.26	Хороодын халуун усны барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11-р хороо/	2007	40.0	40.0
III.1.27	Халуун усны барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16-р хороо/	2007	40.0	40.0
III.1.28	Усан сан /Дархан-Уул, Дархан, 8-р баг/	2007	3.0	3.0
III.1.29	Сумын цэвэр усны нөөцийн сан /Сэлэнгэ, Баянгол/	2007	40.0	40.0
III.1.30	Сумын халуун усны барилга, компьютер, тоног төхөөрөмж /Хөвсгөл, Рашаант/	2007	15.0	15.0
III.1.31	Сумдын ус зөөлрүүлэх төхөөрөмж	2007	11.0	11.0
III.1.32	Сумын халуун усны барилга /Баянхонгор аймгийн Баянлиг, Баянговь, Баянцагаан/	2007	30.0	30.0
III.1.33	Ухсны усны асуудлыг шийдвэрлэх /Хөвсгөл, Ренчинлхумба/	2007	90.0	90.0
III.2	<b>Их засвар:</b>		<b>73.0</b>	<b>73.0</b>

	III.2.1	Халуун усны байрны засвар /Дархан-Уул, Орхон/	2007	4.0	4.0
	III.2.2	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн засвар /Өвөрхангай, Арвайхээр/	2007	25.0	25.0
	III.2.3	Төрийн албан хаагчийн орон сууц /Өвөрхангай, Гучин-Ус/	2007	9.0	9.0
	III.2.4	Ахуйн үйлчилгээний барилгын засвар /Сүхбаатар/	2007	35.0	35.0
	III.3	<b>Тоног төхөөрөмж:</b>		<b>137.0</b>	<b>137.0</b>
	III.3.1	Ундны ус цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж, халуун усны барилга /Төв/	2007	10.0	10.0
	III.3.2	Ундны ус зөөвөрлөх автомашин /Хэнтий, Бэрх/	2007	10.0	10.0
	III.3.3	Хог тээврийн автомашин /Хэнтий, Бэрх/	2007	10.0	10.0
	III.3.4	Усны бойлор тавих /Орхон, Говил бат/	2007	70.0	70.0
	III.3.5	Сумдын ус зөөлрүүлэх төхөөрөмж /Хөвсгөл, Цагаан-Уул, Цэцэрлэг, Арбулаг/	2007	37.0	37.0
		<b>Нийт дүн</b>		<b>5,726.2</b>	<b>5,126.2</b>
IV. МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	IV.1	<b>Хөрөнгө оруулалт</b>		<b>750.0</b>	<b>750.0</b>
	IV.1.1	Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт	2007	750.0	750.0
		<b>Нийт дүн</b>		<b>750.0</b>	<b>750.0</b>
V. ЗРҮҮЛ МЭНДИЙН САЙД	V.1	<b>Хөрөнгө оруулалт:</b>		<b>2,799.9</b>	<b>2,619.9</b>
	V.1.1	Оношлогоо, эмчилгээний төв байгуулах /Улаанбаатар, Клиникийн 3 эмнэлэг/	2007	1,248.0	1,248.0
	V.1.2	Сумын хүн эмнэлгийн барилга, 10 ор /Хөвсгөл, Төмөрбулаг/	2007-2008	200.0	20.0
	V.1.3	Эмийн сангийн барилгын дуусгал /Баянхонгор, Гурванбулаг/	2007	10.0	10.0
	V.1.4	Багийн төв, өрхийн эмнэлгийн барилга /Өвөрхангай, Арвайхээр/	2007	36.0	36.0
	V.1.5	Хүн эмнэлгийн барилга, 10 ор /Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Шар Усны бат/	2007	120.0	120.0
	V.1.6	Өрхийн эмнэлэг /Увс, Улаангом/	2007	45.0	45.0
	V.1.7	Эхчүүдийн амрах байр /Хөвсгөл, Цэцэрлэг/	2007	35.0	35.0
	V.1.8	Хүн эмнэлгийн барилгын өргөтгөл /Ховд, Эрдэнэбүрэн/	2007	50.0	50.0
	V.1.9	Эмчилгээ, оношлогооны төвийн барилга, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 15-р хороо/	2007	111.9	111.9
	V.1.10	Өрхийн эмнэлгийн байр /Хөвсгөл, Мөрөн, 7-р бат/	2007	80.0	80.0
	V.1.11	Хүн эмнэлгийн барилгын өргөтгөл /Увс, Наранбулаг/	2007	50.0	50.0
	V.1.12	Хүн эмнэлгийн барилгын өргөтгөл /Увс, Тариалан/	2007	50.0	50.0
	V.1.13	Хүн эмнэлгийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13-р хороо/	2007	150.0	150.0
V.1.14	Багийн хүн эмнэлгийн байр /Дорнод, Хөлөнбуйр/	2007	10.0	10.0	

V.1.15	Спортын ордон /Өвөрхангай, Арвайхээр/	2007	100.0	100.0
V.1.16	Чийрэгжүүлэх талбай, 12ш /Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Орхон, Шарын гол/	2007	24.0	24.0
V.1.17	Чийрэгжүүлэх талбай /Дорнод, Чойбалсан/	2007	15.0	15.0
V.1.18	Спорт заал /Сүхбаатар, Халзан/	2007	40.0	40.0
V.1.19	Чийрэгжүүлэх талбай /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 1-4 дүгээр хороо/	2007	100.0	100.0
V.1.20	Спорт заалны барилга /Хөвсгөл, Төмөрбулаг/	2007	25.0	25.0
V.1.21	Эмнэлгийн барилгын засвар шинэчлэл /Сэлэнгэ, Шаамар/	2007	15.0	15.0
V.1.22	Эмнэлгийн барилгын засвар шинэчлэл /Сэлэнгэ, Алтанбулаг/	2007	20.0	20.0
V.1.23	2008 оны төсөл эрга хэмжээний зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах	2007	265.0	265.0
V.2	<b>Их засвар</b>		<b>2,346.5</b>	<b>2,346.5</b>
V.2.1	Биеийн тамир спортын хороо, түүний харьяа байгууллагын барилгын засвар	2007	143.0	143.0
V.2.2	Улсын клиникийн төв эмнэлгийн барилгын засвар /Улаанбаатар/	2007	150.0	150.0
V.2.3	Улсын клиникийн II нэгдсэн эмнэлгийн барилгын засвар /Улаанбаатар/	2007	150.0	150.0
V.2.4	Эх нялхасын эрдэм шинжилгээний улсын төвийн барилгын засвар /Улаанбаатар/	2007	100.0	100.0
V.2.5	Нялхасын клиник сувилалын барилгын засвар /Улаанбаатар/	2007	38.1	38.1
V.2.6	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн барилгын засвар /Улаанбаатар/	2007	100.0	100.0
V.2.7	Арьсны өвчин судлалын үндэсний төвийн барилгын засвар /Улаанбаатар/	2007	68.9	68.9
V.2.8	Нэгдсэн эмнэлгийн барилгын засвар /Баян-Өлгий/	2007	150.0	150.0
V.2.9	Нэгдсэн эмнэлгийн барилгын засвар /Дархан/	2007	100.0	100.0
V.2.10	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын засвар /Дорнод/	2007	100.0	100.0
V.2.11	Нэгдсэн эмнэлгийн барилгын засвар /Орхон/	2007	150.0	150.0
V.2.12	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын барилгын засвар /Завхан/	2007	100.0	100.0
V.2.13	Нэгдсэн эмнэлгийн барилгын засвар /Хэнтий/	2007	50.0	50.0
V.2.14	Эрүүл мэндийн байгууллагуудын гэнэтийн засвар	2007	160.0	160.0
V.2.15	Хавдрын эмнэлгийн барилгын их засвар, тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2007	200.0	200.0
V.2.16	Өрхийн эмнэлгүүдийн барилгын засвар /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2007	50.0	50.0
V.2.17	Сумдын эмнэлгийн барилгын цэвэр болон хэрэглээний халуун ус, бохир ус, дамжуулах байгууламж /Архангай аймгийн Эрдэнэмандал, Цэцэрлэг, Жергалзэнт, Хайрхач, Еатцэнгэл/	2007	150.0	150.0
V.2.18	Хүн эмнэлгийн барилгын засвар /Баянхонгор, Хүрээмарал/	2007	15.0	15.0

V.2.19	Хүн эмнэлгийн барилгын засвар /Баянхонгор, Баянбулаг/	2007	10.0	10.0
V.2.20	3 багийн эмчийн үзлэгийн өрөө, албан бус боловсролын сургалтын өрөөний зориулалтаар ашиглагдах барилгын засвар /Баянхонгор, Жаргалант/	2007	3.5	3.5
V.2.21	Эмнэлгийн барилгын засвар /Баянхонгор, Баянцагаан/	2007	13.0	13.0
V.2.22	"Жансая" өрхийн эмнэлэг, багийн конторын барилгын засвар /Баян-Өлгий, Өлгий, 4-р баг/	2007	10.0	10.0
V.2.23	Эмнэлэгийн барилгын тохижилт, их засвар /Баян-Өлгий, Ногооннуур/	2007	14.0	14.0
V.2.24	Багийн хүн эмнэлгийн барилгын засвар /Булган, Сайхан, Сайхан Овоо/	2007	13.0	13.0
V.2.25	Сумын эмнэлгийн барилгын цэвэр усны шугамын холболт /Дорноговь, Эрдэнэ/	2007	7.0	7.0
V.2.26	Сумын хүн эмнэлгийн барилгын засвар /Дорноговь, Хатанбулаг/	2007	25.0	25.0
V.2.27	Сумын хүн эмнэлгийн барилгын засвар /Дорноговь, Улаанбадрах/	2007	20.0	20.0
V.2.28	Сумын хүн эмнэлгийн барилгын засвар /Завхан, Шилүүстэй/	2007	40.0	40.0
V.2.29	Хожуулын голын рашааныг сувиллын газар болгон тохижуулах /Завхан, Тосонцэнгэл/	2007	30.0	30.0
V.2.30	Өрхийн эмнэлгийн барилгын халаалт /Завхан, Улиастай, Товцог баг/	2007	5.0	5.0
V.2.31	Эмнэлгийн барилгын цэвэр болон хэрэглээний халуун ус, бохир ус, дамжуулах байгууламж /Сүхбаатар аймгийн Мөнххаан, Дарьганга, Онгон/	2007	35.0	35.0
V.2.32	Сумын хүн эмнэлгийн барилгын засвар /Ховд, Дуут/	2007	50.0	50.0
V.2.33	Сумын хүн эмнэлгийн барилгын засвар /Дундговь, Цагаандэлгэр/	2007	6.0	6.0
V.2.34	Сумын хүн эмнэлгийн барилгын засвар /Ховд, Мөнххайрхан/	2007	5.0	5.0
V.2.35	Сумын хүн эмнэлгийн барилгын засвар /Хөвсгөл, Бүрэнтогтох/	2007	10.0	10.0
V.2.36	Аймгийн спорт хорооны барилгын засвар /Баянхонгор/	2007	15.0	15.0
V.2.37	Спорт заалны засвар /Өвөрхангай, Хархорин/	2007	60.0	60.0
V.3	<b>Тоног төхөөрөмж:</b>		<b>7,108.1</b>	<b>7,108.1</b>
V.3.1	Телевизийн системтэй дижитал рентген аппарат зураг угаагчийн хамт /Хавдар судлалын төв, Клиникийн нэгдсэн 2 эмнэлэг, Улсын клиникийн төв эмнэлэг, Эх нялхсын эрдэм шинжилгээний төв /	2007	1,070.0	1,070.0
V.3.2	Гэмтлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл	2007	2,000.0	2,000.0
V.3.3	Суурин рентген аппарат зураг угаагчийн хамт /4 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 4 аймгийн нэгдсэн эмнэлэг/	2007	1,175.0	1,175.0
